



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 4/428

Номгон


Баянхонгор сумын 5 дугаар сургуульд сургалтын  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгох тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1.6, Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн “Хуулийн этгээд байгуулах тухай” 84 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 189 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Баянхонгор сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр байгуулагдсан 960 хүүхдийн хүчин чадалтай тавдугаар сургуульд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгосугай.

2.Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн явуулж, багшлах боловсон хүчний чадавхыг сайжруулах, боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд байнга анхаарч ажиллахыг сургуулийн захиралд, шинээр байгуулагдаж байгаа ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, багш ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Энхтөр)-д, сургуулийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН